



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/77-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2024 он

Дарга,

тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 70512123

Аудитор: Ө.Золзаяа

Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
С.СЭЛЭНГЭ ТАНАА

2024.02.25 № 133
танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар түргэн тусламжийн машинтай болж иргэдэд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээ шуурхай цаг хугацаандаа хүрч байна.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үзүүлсэн тусламж үйлчилгээний үр нөлөөтэй байдлыг хангаагүйгээс ЭМДС-аас санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна. Мөн гүйцэтгэлийн санхүүжилтийг нэхэмжлэхдээ Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн тогтоолд заасан шалгуурыг бүрэн хангаж шивээгүй, интернэтийн хурд хангалтгүй, ажил хариуцсан албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 92.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,693,673.95	161,843,316.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,168,239.89	625,943.87
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,168,239.89	625,943.87
31210	Төгрөг	22,168,239.89	625,943.87
31211	Төрийн сангийн харилцах	22,168,239.89	625,943.87
33	АВЛАГА	0.00	18,846,381.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	18,846,381.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,525,434.06	142,370,991.40
35100	Түүхий эд материал	36,020,834.06	77,535,777.40
35110	Тусгай зориулалттай материал	28,210,214.50	24,641,043.50
35130	Эм боох материал	7,810,619.56	52,894,733.90
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	11,589,550.00
35400	Хангамжийн материал	5,504,600.00	53,245,664.00
35410	Бичиг хэргийн материал	251,600.00	5,011,694.00
35420	Аж ахуйн материал	88,000.00	35,718,680.00
35430	Сэлбэг хэрэгсэл	350,000.00	300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	102,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	5,500,000.00
35460	Хүнсний материал	4,815,000.00	6,600,690.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	12,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	606,833,131.39	662,685,691.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	606,833,131.39	662,685,691.10
39200	Биет хөрөнгө	591,045,359.19	631,955,585.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	212,745,075.00	212,745,075.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,536,283.44	-32,329,281.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	160,125,234.00	160,125,234.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,743,838.92	-38,117,482.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	350,784,932.09	462,739,911.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,405,903.27	-188,839,706.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,004,965.00	109,380,165.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,244,433.96	-53,929,328.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,142,250.00	3,142,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,007,637.31	-3,142,250.00
39217	Ном	181,000.00	181,000.00
39300	Биет бус хөрөнгө	15,787,772.20	30,730,105.48
39301	Програм хангамж	3,015,000.00	3,015,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,214,027.80	-1,679,694.52
39303	Бусад биет бус хөрөнгө	13,986,800.00	29,394,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	670,526,805.34	824,529,007.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	25,382,545.24
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	25,382,545.24
41300	Өглөг	0.00	25,382,545.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1.00
41360	Бусад өглөг	0.00	25,382,544.24
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	24,565,044.24
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	817,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	670,526,805.34	799,146,462.13
51	Засгийн газрын хувь оролцоо	670,526,805.34	799,146,462.13

51100	Засгийн газрын оруулсан капитал	333,437,596.80	348,845,596.80
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	333,437,596.80	348,845,596.80
51200	Хуримтлагдсан үр дүн	304,396,214.06	417,607,870.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-285,551,272.53	304,396,214.06
51220	Тайлант үеийн үр дүн	589,947,486.59	113,211,656.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,692,994.48	32,692,994.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	670,526,805.34	824,529,007.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,445,500,357.26	961,020,526.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	670,169,647.26	125,093,800.57
120	Нийтлэг татварын бус орлого	670,169,647.26	125,093,800.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	988,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	988,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	593,644,184.03	108,459,979.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	75,537,463.23	16,633,821.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	775,330,710.00	835,926,726.17
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,314,300.00	49,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,314,300.00	49,050,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	749,016,410.00	786,876,726.17
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	749,016,410.00	786,876,726.17
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	855,552,870.67	847,808,869.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	855,552,870.67	847,808,869.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	855,552,833.05	840,698,451.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,514,296.82	434,712,186.81
210101	Үндсэн цалин	291,732,212.31	329,487,193.84
210102	Нэмэгдэл	63,001,564.35	67,262,261.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,586,000.00	5,086,849.00
210104	Урамшуулал	63,947,939.16	32,477,467.50
210105	Гэрээт ажлын хөлс	2,246,581.00	398,415.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,158,588.14	98,956,470.08
210201	Тэтгэврийн даатгал	52,205,590.35	70,755,870.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,808,960.67	7,050,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,430,173.96	5,640,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	760,003.67	1,409,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,953,859.49	14,100,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,022,012.38	40,504,842.66
210301	Гэрэл, цахилгаан	4,885,834.78	8,993,038.56
210302	Түлш, халаалт	15,536,177.60	31,511,804.10
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,048,449.60	58,754,071.00
210401	Бичиг хэрэг	9,291,018.54	2,235,700.00
210402	Тээвэр, шатахуун	34,425,982.00	42,097,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,774,550.00	1,787,500.00
210404	Ном, хэвлэл	16,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,125,100.00	1,609,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,952,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	16,415,799.06	9,071,991.00
2105	Нормативт зардал	181,095,784.07	101,486,500.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,003,464.07	75,871,047.47
210502	Хоол, хүнс	31,862,620.00	25,615,453.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,229,700.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,643,622.50	3,181,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,753,672.50	1,067,100.00
210602	Тавилга	3,225,000.00	0.00
210604	Урсгал засвар	4,664,950.00	2,114,000.00
2107	Томилолт, зочны зардал	608,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	608,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,558,021.90	6,626,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,305,021.90	6,626,061.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,904,057.64	96,477,219.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,118,700.00	2,591,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,785,357.64	93,885,619.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37.62	7,110,418.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5,649,121.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	5,649,121.30
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,461,297.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,461,297.34
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37.62	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37.62	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	589,947,486.59	113,211,656.79
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	589,947,486.59	113,211,656.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	856,898,028.75	817,080,345.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,060,118.75	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,060,118.75	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,060,118.75	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	988,000.00	0.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	7,072,118.75	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	848,837,910.00	817,080,345.17
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,314,300.00	49,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,314,300.00	49,050,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	822,523,610.00	768,030,345.17
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,523,610.00	768,030,345.17
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	753,755,483.86	812,752,441.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	753,755,483.86	812,752,441.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753,755,446.24	802,472,022.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,514,296.82	434,712,185.81
210101	Үндсэн цалин	287,395,610.54	321,941,478.58

210102	Нэмэгдэл	67,338,166.12	74,807,975.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,586,000.00	5,086,849.00
210104	Урамшуулал	63,947,939.16	32,477,467.50
210105	Гэрээт ажлын хөлс	2,246,581.00	398,415.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,158,588.14	98,956,470.08
210201	Тэтгэврийн даатгал	52,205,590.35	70,755,870.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,808,960.67	7,050,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,430,173.96	5,640,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	760,003.67	1,409,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,953,859.49	14,100,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,134,634.78	42,138,702.66
210301	Гэрэл, цахилгаан	4,885,834.78	8,993,038.56
210302	Түлш, халаалт	13,648,800.00	33,043,664.10
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	102,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,938,182.00	58,097,954.00
210401	Бичиг хэрэг	7,548,000.00	5,846,834.00
210402	Тээвэр, шатахуун	35,568,732.00	36,303,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,751,250.00	1,885,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,070,200.00	8,473,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	5,589,200.00
2105	Нормативт зардал	155,555,645.00	106,386,049.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,073,595.00	76,442,025.00
210502	Хоол, хүнс	31,501,250.00	21,267,784.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,980,800.00	8,676,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,853,827.60	37,805,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,674,800.00	12,832,500.00
210602	Тавилга	1,997,000.00	10,203,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	590,000.00	994,800.00
210604	Урсгал засвар	11,592,027.60	13,774,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,213,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,213,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,876,171.90	6,576,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,623,171.90	6,576,061.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,511,100.00	17,798,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,511,100.00	17,798,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37.62	10,280,418.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,819,121.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	8,819,121.30
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	1,461,297.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,461,297.34
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37.62	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37.62	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	103,142,544.89	4,327,903.98
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	80,974,305.00	25,870,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,974,305.00	25,870,200.00

2200	Дотоод эх үүсвэрээр	80,974,305.00	25,870,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,974,305.00	25,870,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-80,974,305.00	-25,870,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	22,168,239.89	-21,542,296.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	22,168,239.89
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,168,239.89	625,943.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	-285,551,272.53	80,579,318.75
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	-285,551,272.53	80,579,318.75
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	589,947,486.59	589,947,486.59
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	304,396,214.06	670,526,805.34
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	304,396,214.06	670,526,805.34
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	304,396,214.06	670,526,805.34
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	15,408,000.00	0.00	0.00	15,408,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	113,211,656.79	113,211,656.79
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	348,845,596.80	32,692,994.48	417,607,870.85	799,146,462.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,038,336,300.00	789,572,641.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,038,336,300.00	789,572,641.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,029,336,300.00	780,753,519.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,354,000.00	434,712,185.81
210101	Үндсэн цалин	422,685,900.00	321,941,478.58
210102	Нэмэгдэл	128,423,800.00	74,807,975.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,625,000.00	5,086,849.00
210104	Урамшуулал	63,619,300.00	32,477,467.50
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	398,415.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,374,700.00	98,956,470.08
210201	Тэтгэврийн даатгал	89,174,100.00	70,755,870.08
210202	Тэтгэмжийн даатгал	7,550,500.00	7,050,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,040,500.00	5,640,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,510,000.00	1,409,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,099,600.00	14,100,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,367,000.00	60,008,754.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	5,846,834.00
210402	Тээвэр, шатахуун	38,297,000.00	36,303,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,070,000.00	1,885,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,500,000.00	8,473,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,500,000.00	7,500,000.00

2105	Нормативт зардал	128,021,500.00	106,386,049.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,626,200.00	76,442,025.00
210502	Хоол, хүнс	28,135,300.00	21,267,784.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,260,000.00	8,676,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,315,500.00	55,952,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,940,800.00	20,411,500.00
210602	Тавилга	25,874,700.00	22,067,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	994,800.00
210604	Урсгал засвар	17,500,000.00	12,478,400.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,750,300.00	6,576,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,750,300.00	6,576,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,903,300.00	18,161,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,903,300.00	18,161,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,000,000.00	8,819,121.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	8,819,121.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,000,000.00	8,819,121.30
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,038,336,300.00	768,030,345.17
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,016,168,100.00	768,030,345.17
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,016,168,100.00	768,030,345.17
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	22,168,200.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,168,200.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	22,168,239.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	625,943.87

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 131,725.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 125,093.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,926.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1,705.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн дутуу санхүүжилттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 125,093.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу илэрхийлснийг залруулсан.

3.2 Төлбөрийн акт

Цалин нэмэгдэл, ээлжийн амралтын нөхөн олговрын тооцоололтой холбоотой:

- Ажилчдын ээлжийн амралтын нөхөн олговрын 1 өдөрт ногдох дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос 391.5 мянган төгрөгийг дутуу бодож олгосон байна.
- Эмэгтэйчүүдийн их эмчийн цалингийн нэмэгдлийг 6 сард 20 хувь, 9 сард 20 хувиар буюу нийт 473.8 мянган төгрөгийн нэмэгдлийг дутуу олгосон.
- Эрүүл мэндийн төвийн эрхлэгч албан ажлын шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй нөхөн олговор 1,586.1 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Өмнөх оны аудитаар тогтоосон тооцооллын алдаанаас үүссэн ээлжийн амралтын нөхөн олговрыг 810.1 мянган төгрөгөөр илүү олгосон.
- Нягтлан бодогчид тушаал шийдвэргүйгээр 1,664.7 мянган төгрөгийн нэмэгдэл илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*), Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2 (Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.1.2 дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

3.3 Албан шаардлага

3.3.1 Тайлант онд цалингийн зардлаас байгууллагын 2022 оны шилдэг ажилтанд 1,705.5 мянган төгрөгийн мөнгөн шагнал, урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*) дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2 Ээлжийн амралтын нөхөн олговрын нэг өдрийн дундаж цалин хөлсийг буруу тооцоолж, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 60-аас доош хувийн гүйцэтгэлтэй хангаж албан үүргээ хуулийн дагуу хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*) дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үзүүлсэн тусламж үйлчилгээний үр нөлөөтэй байдлыг хангаагүйгээс ЭМДС-аас санхүүжилтийг бүрэн авч чадаагүй байна. Мөн гүйцэтгэлийн санхүүжилтийг нэхэмжлэхдээ Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн тогтоолд заасан шалгуурыг бүрэн хангаж шивээгүй, интернэтийн хурд хангалтгүй, ажил хариуцсан албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Өгсөн зөвлөмж: ЭМДҮЗ-ийн шалгуурт нийцүүлэх, хариуцсан мэргэжилтэн бүрийн хариуцлагыг дээшлүүлж үр дүнгийн гэрээнд оруулж ажил дүгнэхтэй холбож өгөх, тоног төхөөрөмж интернэтийн хурдыг дээшлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогыг дутуу тайлагнасан	1	125,093.7			1	125,093.7	1	125,093.7				
Дүн	1	125,093.7			1	125,093.7	1	125,093.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин нэмэгдэл, нөхөн олговрыг илүү, дутуу олгосон	1	4,926.2	1	4,926.2								
Цалингийн зардлаас зориулалт бусаар зарцуулсан	1	1,705.5			1	1,705.5						
Зөрчлийг давтан гаргасан	1	-							1	1		
Дүн	3	6,631.7	1	4,926.2	1	1,705.5			1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Эрүүл мэндийн даатгалын 248,137.8 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан	1	-			1	-
Нийт дүн	1	-	-	-	1	-

Нэг цагийн дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг дутуу бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.1 /дундаж цалин хөлс тодорхойлох журам;/, Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.1.3 дахь заалтад нийцэхгүй байна.